



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/95

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 2 дугаар зөвлөмжийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил (Өвөрхангай, Арвайхээр сум) ЗТХЯ/201901063 тоот тендерийг 9968218400 (есөн тэр бум есөн зуун жаран найман сая хоёр зуун арван найман мянга дөрвөн зуу) төгрөгөөр Өндөрсант хайрхан, Эвт-Уул ХХК-иудын түншлэлээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100220